

Таван богд Констракшн Машинери

| | |
|-----------------------------------|--|
| Байршил: | Монгол |
| Төслийн дугаар: | 56736 |
| Бизнесийн салбар: | Үйлдвэрлэл, үйлчилгээ |
| Мэдээллийн төрөл: | Хаалттай |
| Байгаль орчны нөлөөллийн ангилал: | |
| Батлагдах огноо: | 2026 оны 06 дугаар сарын 17 |
| Төлөв байдал: | Эцсийн хяналтад тэнцсэн, батлагдахыг хүлээж буй |
| ТХББ-г нийтэд ил болгосон огноо: | 2026 оны 05 дугаар сарын 08 |

Төслийн танилцуулга

Таван Богд Констракшн Машинери ХХК-д цаашид ("Компани" эсвэл "Харилцагч" гэх) 40 сая хүртэлх ам.доллартай тэнцэхүйц төгрөгийн барьцаат зээл олгох төсөл. Зээл нь баталгаажсан болон баталгаажаагүй хоёр тэнцүү хэсгээс бүрдэнэ. Баталгаажсан хэсэг нь орчин үеийн ложистик, засвар үйлчилгээний төв, болон төв оффисын барилга барьж ашиглалтад оруулахад зарцуулагдана. Баталгаажаагүй хэсэг нь борлуулалт болон үйлчилгээний үйл ажиллагаа өргөжихтэй холбоотой нэмэлт эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг санхүүжүүлнэ. Энэхүү төсөл нь компанийн засвар үйлчилгээ, сэргээн засварлах чадавхыг сайжруулж, компанийн хүнд машин механизмын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Төслийн зорилго

Энэхүү төсөл нь ЕСБХБ-ны Монгол Улсын хувьд баримтлах бодлоготой нийцэж байгаа бөгөөд илүү хүчтэй, илүү төрөлжсөн, тогтвортой хувийн хэвшлийг бий болгох замаар Монгол Улсын тогтвортой байдлыг дэмжих юм.

Шилжилтийн нөлөөлөл

Шилжилтийн нөлөөллийн оноо: 65

Төслийн шилжилтийн нөлөөлөл нь голчлон Ногоон шилжилтийн чанараас үүдэлтэй бөгөөд Өрсөлдөх чадварын хүрээнд нэмэлт үр өгөөжтэй байна. Анхдагч шилжилтийн чанар – Ногоон чанар нь үндэсний стандартыг давсан Эрчим хүчний хэмнэлтийн В ангиллыг хангасан засвар, үйлчилгээний шинэ байгууламж барьснаар хэрэгжинэ. Энэхүү байгууламж нь эрчим хүчний хэмнэлт бий болгож, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах болно. Баталгаажсан хэсэг нь Ногоон эдийн засгийн шилжилтийн (GET) санхүүжилтийн 100% шаардлага хангана. Мөн тус төсөл нь компанийн борлуулалтын дараах үйлчилгээ, засвар үйлчилгээний хүчин чадлыг өргөжүүлж сэлбэгийн засвар, дахин үйлдвэрлэл болон үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг сайжруулах замаар Өрсөлдөх чадварын шилжилтийн чанарыг дэмжинэ.

Зээлдэгчийн талаарх мэдээлэл

Таван Богд Констракшн Машинери ХХК

Таван Богд Констракшн Машинери ХХК нь Монгол Улс дахь Хитачи брендийн уул уурхай, барилгын хүнд машин механизмын албан ёсны онцгой эрхтэй борлуулагч. Компанийн 90%-ийг Монголын томоохон, олон салбарт тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг, аж үйлдвэр, үйлчилгээ, хэрэглээний салбарт өндөр амжилт тогтоосон Таван Богд Холдингс ХХК эзэмшдэг.

ЕСБХБ-ны Санхүүжилтийн дүн

143,000,000,000.00 төгрөг

Төслийн нийт өртөг

143,000,000,000.00 төгрөг

Нэмэлт үр дүн

Төслийн зээлийн хугацаа нь одоогийн дотоодын зах зээлд санал болгогдож буй хугацаанаас урт байна. Банкны нэмэлт үр нөлөө нь үндэсний стандартын дагуу төслийн барилга нь эрчим хүчний хэмнэлтийн В ангилалд хүрч буйтай холбоотой бөгөөд энэ нь дотоодын стандартаас нэг түвшин өндөр үзүүлэлт юм.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

В ангилал (2024 ESP).

Төслийн хүрээнд үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн (E&S) эрсдэл болон нөлөөллүүд нь тодорхой, тухайн газар нутгийг хамарсан бөгөөд зохих бууруулах арга хэмжээ болон зорилтот Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны

төлөвлөгөөгөөр (ESAP) дамжуулан шийдвэрлэх боломжтой юм. Төслийн байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээ (ESDD)-г дотооддоо гүйцэтгэсэн бөгөөд үүнд харилцагч компанийн корпорейт түвшний үйл ажиллагааны үнэлгээ, мөн шинээр байгуулах засвар үйлчилгээний төвийн (төв) санал болгож буй байршлын зайнаас хийсэн үнэлгээ багтсан. ESDD-г байгаль орчин, нийгмийн асуумж, 2025 оны ISO дотоод аудитын тайлангийн хяналт, ISO 45001 стандартын хамрах хүрээ болон энэ нь харилцагчийн үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж буйг баталгаажуулах, мөн төлөвлөж буй төвийн концепцын ерөнхий зураг төслийг хянах замаар хэрэгжүүлсэн. Түүнчлэн санал болгож буй байршил болон газрын талбайн зургуудыг веб суурьтай аппликейшн ашиглан шалгасан. ESAP-ийн хүрээнд харилцагч нь төсөлд зориулсан байгаль орчин, нийгмийн үнэлгээг гүйцэтгэх, байгаль орчны менежментийн тогтолцоогоо бэхжүүлэх, мөн жендэрт суурилсан хүчирхийлэл болон дарамтын (GBVH) үнэлгээ хийх үүрэгтэй. Мөн ажилчдын эрхийн хэрэгжилтийг хангах, шаардлагатай бүх барилга угсралт болон байгаль орчны зөвшөөрлийг авах, түүнчлэн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (OSH) болон аюултай материалын менежментийн үр дүнтэй зохицуулалтыг хэрэгжүүлэх үүргийг хамарна. Нэмж дурдахад, үйл ажиллагаа эхэлсний дараа харилцагч нь авто замын хөдөлгөөний нөлөөллийг үнэлж, оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бөгөөд ESAP-ийн хэрэгжилтийн явцын шинэчлэлтийг багтаасан байгаль орчин, нийгмийн (E&S) жилийн хяналтын тайланг Банкинд хүргүүлнэ.

Ногоон санхүүжилтийн ангилал

Парисын хэлэлцээрийн нийцэл

Төсөл нь ЕСБХБ-ны шууд хөрөнгө оруулалтын Парисын хэлэлцээрийн нийцлийг тодорхойлох арга зүйн хүрээнд Парисийн хэлэлцээрийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох зорилтуудтай нийцсэн гэж тодорхойлогдсон. Энэхүү төсөл нь олон улсын хөгжлийн банкуудын хамтарсан нийцлийн жагсаалтад "Барилга байгууламж, нийтийн байгууламж" гэсэн ангилалд багтсан тул Парисын хэлэлцээрийн нөлөөллийг бууруулах зорилтуудтай нийцэж байгаа юм. Энэхүү төсөл нь цаг уурын биет байдлын бодит эрсдэл байхгүй бөгөөд дасан зохицох үндэсний бодлого эсвэл өргөн хүрээний системийн уур амьсгалд тэсвэртэй байдлыг зөрчөөгүй учир Парисын хэлэлцээрийн дасан зохицох зорилтуудтай нийцэж байгаа болно.

Ногоон санхүүжилтийн ангилал

ЕСБХБ-ны санхүүжилтийн 50% нь уур амьсгалын нөлөөллийг бууруулах зорилтод хүрэх үйл ажиллагааг дэмжих тул ногоон санхүүжилт гэж ангилагдана. Энэхүү ангиллыг ЕСБХБ-ны хөрөнгө оруулалтын ногоон санхүүжилтийн

ангиллыг тодорхойлох аргачлал болон тус аргачлалын “Барилга байгууламж” хэсэгт заасан тусгай зааварчилгааны дагуу хийсэн болно.

Техникийн туслалцаа ба буцалтгүй тусламжийн санхүүжилт

Төсөл нь барилгын салбар дахь хамгийн сайн, дотоодын нөхцөл байдалд шинэлэг технологи ашиглахад зориулсан, Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр санхүүжилт, технологи дамжуулах төв (FINTECC)-ийн буцалтгүй тусламжийн ашиг тусыг хүртэх болно. Уг буцалтгүй тусламж нь шинэ засвар үйлчилгээний байгууламжийн барилгын ажилд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Компаний холбоо барих хүний мэдээлэл

Намхай Отгонбаатар

tbg-businessmanager@tavanbogd.com

+976-95994345

<https://tavanbogd.com>

Хаан банк цамхаг 10 давхар, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө - 6, Ulaanbaatar 17010, Mongolia

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр

судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алианаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.